



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2023 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 09/02

Хөхбүрд

**Санал хүргүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дах заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит наймдугаар хуралдаанаас **ТОГТООХ** нь

1. Аймгийн Засаг даргаас ирүүлсэн “Хүсэлт хүргүүлэх тухай” 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 1а/926 тоот албан бичигт дурьдсан Улаан сайрын ам нэртэй газарт 57.26 гектар талбайд ашигт малтмалын газрын тосны газраас ирүүлсэн дүгнэлтээр түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох эсэхийг хэлэлцээд барилгын материалын зориулалтаар ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг аймаг сумаас хол малчдын малын бэлчээр бүхий газар олгохоос татгалзсан хариу хүргүүлсүгэй.

2. Хуралдаанаас гарсан шийдвэр холбогдох бичиг баримтын хамт аймгийн Засаг даргад хүргүүлэхийг Хурлын нарийн бичгийн дарга (М.Энхцэцэг)-т үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж биелэлтийг тооцож ажиллахыг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэдэх Байгаль орчин хөдөөгийн хөгжлийн хороонд даалгасугай.

ДАРГА  Б.ОТГОНБАЯР

хөрөнгө бүртгэх ажлыг зохион байгуулахыг сумын Засаг дарга (Ж.Хатанбаатар)-т даалгасугай.

3. Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж журмын дагуу нягтлан бодох бүртгэл тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд бүртгэхийг сумын төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.

Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргад даалгасугай.

ДАРГА  Б.ОТГОНБАЯР

